



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/17

Улаанбаатар хот

### Эцэг эхийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын “Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай” 2018 оны 01 дүгээр албан даалгавар, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл батлах тухай” 2018 оны 03 дугаар тогтоол, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын хэмжээнд ажилтнуудын гэр бүл, хүүхдэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн боловсролын ач холбогдлыг сурталчлан таниулах, сургалт зохион байгуулах, хүүхдэд ээлтэй байгууллага хамт олныг бий болгоход дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллагын Эцэг эхийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. “Эцэг эхийн зөвлөл”-ийн жилийн ажлын төлөвлөгөөг батлуулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Зөвлөлийн дарга (С.Туул)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/23 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Д.Ганболд)-т даалгасугай.

ДАРГА *D. Batsukh* Д. БАТСҮХ



1150500116

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2023 оны 04 дүгээр сарын 18-ны  
өдрийн А.17 дугаар тушаалын хавсралт



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:	С.Туул	Маркетинг сурталчилгаа хариуцсан ахлах мэргэжилтэн
Гишүүн	Ч.Энх-Отгон	Хяналт үнэлгээ, статистик судалгаа, дүн шинжилгээ хариуцсан мэргэжилтэн
	О.Нямбат	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн
	Т.Батдорж	Дотоодын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга	Б.Цолмонгэрэл	Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан мэргэжилтэн